

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ШИЙДВЭРЭЭС ГАРСАН, АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНААР БАТЛАГДСАН ШИЙДВЭРҮҮДИЙН БИЕЛЭЛТ**

2022.12.12

Арвайхээр

Д/д	Тогтоолын дугаар	Тогтоолын тэргүү (Агуулга)	Биелэлт	Хувь
1.	2012.10.09 дугаар 101	Журам батлах тухай	<p>-Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4-д төрийн захиргааны төв байгууллагын баталсан дээд хязгаарт багтаан тухайн жилд ойгоос бэлтгэх хэрэглээний мод, түлээний хэмжээг сумдаар хуваарилан батлана гэж заасны дагуу аймгийн нутаг дэвсгэрээс 2023 онд ойгоос бэлтгэх модны тоо хэмжээг аймгийн ИТХ-ын 2022 оны 14/01 дугаар тогтоолоор батлуулж хэрэгжилтийг ханган ажиллалаа.</p> <p>-Дугуй хөрөө ажиллуулах журмын дагуу Өвөрхангай аймагт ойгоос бэлтгэсэн хэрэглээний бөөрөнхий модыг боловсруулах, зүсмэл материал үйлдвэрлэх зориулалтаар Бат-Өлзий, Хужирт, Хархорин, Арвайхээр сумдын ойн арчилгаа цэвэрлэгээ хийх мэргэжлийн байгууллагын эрх бүхий 11 аж ахуйн нэгж, мод, модон материалын 2 захад нийт 12 хөрөө рам ажиллаж байна. Эдгээр хөрөө рамууд нь бүгд 380 вольтын хүчдэлээр ажилладаг бөгөөд ажлын байр, хөдөлмөр хамгаалал, гал түймрийн аюулгүй ажиллагаа, стандартын шаардлага хангасан БНХАУ, ОХУлсад үйлдвэрлэсэн туузан болон “Тайга” загварын хөрөөнүүд байна. Хөрөө рамуудын үйл ажиллагаанд сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Байгаль хамгаалагч нар тогтмол хяналт тавьж ажилладаг. Холбогдох газраас зөвшөөрөл авч экологийн хариуцлагын гэрээ байгуулаагүй, хяналтын камергүй, бичиг баримтын бүрдэл дутуу, ажлын байранд тавигдах шаардлага хангаагүй шалтгаанаар хууль хяналын байгууллагаас Арвайхээр суманд 3, Бат-Өлзий суманд 4 хөрөө рамын үйл ажиллагааг зогсоосон байна.</p>	100
2.	2013.11.07 дугаар 89	Агнуурын бүс нутаг тогтоох тухай	<p>–“Амьтны тухай хууль”, Агнуур зохион байгуулалтын мэргэжлийн байгууллагын ажиллах журам, Ан агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулах үлгэрчилсэн загвар, аргачлал, бусад хууль журмын дагуу 2018-2022 онд хэрэгжих Өвөрхангай аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалт, ан агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулах, аймгийн нутагт агнуурын амьтдын зүйлүүдийг хамгаалж, өсгөн үржүүлэх, зохистой ашиглалтыг бий болгох арга замыг тодорхойлох ажлыг байгаль орчны мэргэжлийн байгууллага “Аргаль, агнуур судлалын төв” ТББайгууллагаар хийлгүүлж, хэрэгжилтийг ханган ажилласан.</p> <p>-Аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалт, менежментийн төлөвлөгөөний</p>	100

			<p>хугацаа дуусч байгаатай холбогдуулан 2023 онд ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгааны ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэхээр төлөвлөөд байна.</p> <p>-2022 онд 13 сумаас 71 идлэг шонхор шувууг тусгай зориулалтаар бариулж, “Маунтэйн хантинг” ХХК, “Монгол Сафари” ХХК, “Атон-аммон” ХХК, “Ан жентур” ХХК тусгай зориулалтын ан хийж, ан амьтны нөөц ашигласны төлбөр-2,4 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.</p> <p>-Нэн ховор, ховор амьтдад болох аргаль, янгир, халиун буга, бор гөрөөс зэрэг амьтдад биотехникийн арга хэмжээ авах ажлыг агнуурын бүс нутгуудад зохион байгууллаа. Нийт 10 сумын 36 цэгт 5 тонн хужир тавьж, тус ажилд сумдын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнүүд, байгаль хамгаалагчид, нөхөрлөлийн гишүүд хамтран зохион байгуулж байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 10,0 сая төгрөг зарцууллаа.</p>	
3.	2017.05.19 дугаар 48	Гэрээний загвар батлах тухай	<p>Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй олборлох үйл ажиллагаа явуулж байгаа “Баянтээг”ХК, “Баярсгоулд”ХХК, “Өгөөмөр-Өргөө”ХХК, “АУМ-Алт”ХХК-иуд орон нутагтай байгаль орчныг хамгаалах, дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан, биелэлтийг жил бүр дүгнэж байна. Нийгмийн хариуцлагын хүрээнд 2021 онд Баянтээг ХК аймгийн төсөвт 1,0 тэрбум, Уянга суманд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд 350,0 сая төгрөгийн дэмжлэг тус тус үзүүлсэн.</p> <p>2022 онд Уянга сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй “Өгөөмөр-Өргөө” ХХК сумын Цагдаа, Байгаль орчны байцаагч, Байгаль хамгаалагч нарыг унаажуулах, 1 га ногоон байгууламжийн хашаа барихад 94,4 сая төгрөг, “Баярсгоулд” ХХК цэцэрлэгт хүрээлэн болон нийтийн эзэмшлийн зам талбайн дагуу 600 ширхэг мод, бут тарьж хашаажуулах, Бөөрөлжүүлтийн голын гүүрийн далангийн ажилд 70,0 сая төгрөг, “АУМ-Алт” ХХК сумын төвд 0,5 га газарт 1200 ширхэг мод, бут тарьж хашаажуулахад 75,0 сая төгрөг, Арвайхээр суманд 2000 ширхэг хайлаас мод, бут, 4 гүн өрмийн худаг гаргах зардалд нийт 60,4 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Баруунбаян-Улаан сумын нутаг дэвсгэрт газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулж буй “Капкорп монголиа” ХХК сумын төвийн нэгдсэн хогийн цэгийг ангилах, дарах зэрэг ажилд 36,7 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Баян хөх толгой” ХХК Төгрөг сумын эрүүл мэнд, боловсролын байгууллагуудад 135,6 сая төгрөгийн эд материалын дэмжлэг үзүүлсэн.</p>	100
4.	2017.05.19 дугаар 46	Зөвлөл байгуулж, түүний ажиллах журам	<p>Тус зөвлөл нь аймгийн эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, улсын болон гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх геологийн судалгааны үр дүнгийн тайлан сонсох, уурхайн нөхөн сэргээлтийн асуудал зэрэг журамд заагдсан 11 чиг үүргийн дагуу</p>	100

		батлах тухай.	<p>асуудлыг хэлэлцэн ажиллаж байна.</p> <p>Зөвлөл нь “Аймгийн эрдэс баялгийн зөвлөлийн ажиллах журам”-ын хэрэгжилтийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 10 сарын 11-ны өдрийн хуралдаанд хэлэлцүүлэн ажилласан.</p> <p>Мөн тус зөвлөлийн гишүүд аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/316 дугаар захирамжаар байгуулагдсан ашигт малтмал олборлолтын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж, орхигдсон газруудад нөхөн сэргээлт хийлгэх, нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгжүүдэд хуулийн хариуцлага тооцуулж, нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх зорилго бүхий ажлын хэсэгт орж сумдад ажиллан нөхөн сэргээлтийн талаар авч хэрэгжүүлэх зөвлөмж гаргаж, хэрэгжүүлж ажиллах чиглэлийг аймгийн Засаг даргын 2021 оны 07 сарын 09-ны өдрийн 1/362 дугаар албан бичгээр сумдад хүргүүлж, нөхөн сэргээлтийн талаар авч хэрэгжүүлсэн ажлын тайланг сумдаас авч ажилласан. Зөвлөмжийн дагуу ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд 2021 онд техникийн нөхөн сэргээлтийг 67.49 га, биологийн нөхөн сэргээлтийг 7 га талбайд, 2022 онд техникийн нөхөн сэргээлтийг 55.5 га, биологийн нөхөн сэргээлтийг 10.5 га талбайд, бичил уурхайн нөхөрлөлүүд техникийн нөхөн сэргээлтийг 15 га талбайд буюу нийт 155.49 га талбайд хийж аймаг, сумын ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн.</p> <p>Шүүхийн шийдвэрийн дагуу хууль бус үйл ажиллагаа явуулсан иргэдээс төвлөрүүлсэн байгаль орчинд учруулсан хохирол, нөхөн сэргээлтийн зардлаар Уянга сумын Бөөрөлжүүтийн голд нөхөн сэргээлт хийх сонгон шалгаруулалтад “АУМ-Алт” ХХК шалгарч нөхөн сэргээлт хийх гэрээ байгуулсан гэрээний дагуу 2021 онд 9.2 га талбайд нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэлийг гүйцэтгэсэн. Гар аргаар ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж нөхөн сэргээгдээгүй орхигдсон 81.29 га газрыг нөхөн сэргээх зорилгоор бичил уурхайн зориулалтаар аймгийн ИТХурлын 2022 оны 04 сарын 12-ны өдрийн 10/06 дугаар тогтоолоор тусгай хэрэгцээнд авсан.</p>	
5.	2021.02.09 Дугаар 08	Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай	<p>Хужирт сумын халуун рашаан, шавар, цэвэр усны нөөцийг дахин үнэлэх судалгааны ажлыг эрх бүхий “Карт” ХХК нь 2018-2019 онд хийж гүйцэтгэсэн. Судалгааны ажлын үр дүнг 2019 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн “Усны нөөцийн зөвлөл”-ийн хурлаар хэлэлцүүлэн, халуун рашаан 1742.43 м<sup>3</sup> /хоног, цэвэр усны нөөцийг 590.0 м<sup>3</sup>/ хоногоор тогтоож, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А/183 дугаар тушаалаар батлагдсан. Хужирт суманд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 3 тэрбум 298 сая төгрөгөөр сумын нэгдсэн цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлыг “Санжат” ХХК гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Үүнд 50м</p>	70

			гүнтэй цэвэр усны гүний худаг гаргаж, 3120 м урттай бохир усны шугам тавих, захиргаа, уурын зуухны барилга байгууламжыг байгуулсан. “Шинэ сум” төслийн хүрээнд улсын төсвийн 3.7 тэрбум төгрөгийн хөрөнгөөр “Цагаан зуун” ХХК Хайрхандулаан сумын төвд 50 м3/хон хүчин чадалтай цэвэрлэх байгууламж, гүн өрмийн 2 худаг, 100 м3 багтаамжтай усан сан, ухаалаг системтэй ус түгээх байр 2 ш, 840 м урт дулааны шугам, 5190 м урт цэвэр усны шугам, 3190 м урт бохир усны шугам зэрэг байгууламжийг байгуулан ашиглалтад оруулсан.	
6.	2018 оны Дугаар 07/01	Газар нутгийг бичил уурхайн зориулалтаар тусгай хэрэгцээнд авах тухай /5 жил/	Засгийн газрын 2017 оны 151 дугаар тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын дагуу аймгийн ИТХ-ын 2018 оны 07/01 дугаар тогтоолоор Хайрхандулаан, Баруунбаян-Улаан сумдын 46 га газрыг бичил уурхайн зориулалтаар тусгай хэрэгцээнд авч, Ашигт малтмал, газрын тосны газраар дүгнэлт гаргуулан сумдын Засаг дарга бичил эрхлэгчидтэй 2018-2019 онд гэрээ байгуулан ажиллаж тухайн газарт нөхөн сэргээлтийн ажлыг хийлгэж ажилласан. Дээрх журмын дагуу гар аргаар алт олборлогч иргэдийн эвдрэлд оруулж, нөхөн сэргээгдээгүй орхигдсон газар бүрэн нөхөн сэргээгдэж, байгалийн унаган төрхдөө ойртож, 100 гаруй иргэн нөхөрлөлийн зохион байгуулалтад орж татвар, эрүүл мэнд, нийгмийн даатгал төлж, түр ажлын байраар хангагдан орлогоо нэмэгдүүлж ажилласан.	100
7.	2019 оны Дугаар 10/01	Газар нутгийг тусгай хэрэгцээнд авах тухай	“Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын дагуу аймгийн ИТХ-ын 2019 оны 10/01 дугаар тогтоолоор Нарийнтээл сумын 34 га газрыг бичил уурхайн зориулалтаар тусгай хэрэгцээнд авч, Ашигт малтмал, газрын тосны газраар дүгнэлт гаргуулан сумдын Засаг дарга бичил эрхлэгчидтэй гэрээ байгуулан ажиллаж тухайн газарт нөхөн сэргээлтийн ажлыг хийлгэж ажилласан.	100
8.	2019 оны Дугаар 11/01	Журам батлах тухай	-Аймгийн хэмжээнд бүх нийтийн их цэвэрлэгээг улирал бүр зохион байгуулж, 2022 онд нийт 4 удаагийн их цэвэрлэгээгээр давхардсан тоогоор 36659 иргэн оролцож, 7096 тн хог хаягдлыг цэвэрлэж, төвлөрсөн хогийн цэгт хүргэх ажлыг зохион байгуулж, 2022 онд бүх нийтийн хог цэвэрлэгээ болон төвлөрсөн хогийн цэгийн хог хаягдлыг ангилан ялгах нийтийг хамарсан ажлын хүрээнд 400 түр ажлын байр бий болж, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас 160,0 сая төгрөг зарцуулсан байна. -Аймгийн БОАЖГ, Онги-Тааз голын сав газрын захиргаа, Зэвсэг хүчний 256 дугаар ангитай хамтран аймгийн хэмжээнд нийт 161 уст цэг болон гадаргын усны ойр орчмыг цэвэрлэх ажлыг 2 удаа зохион байгуулж, Орхон, Онги, Таац, Дайрга, Ар-Агуйн гол, Найман нуур, Ногоон нуур, Таацын цагаан нуур, Хүрэмт нуур орчмын хог хаягдлыг цэвэрлэж, нийт 85,1 тн хог хаягдлыг төвлөрсөн	100

			<p>хогийн цэгүүдэд хүргэж ажилласан.</p> <p>-Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах дадал хэвшлийг айл өрхүүдэд хэвшүүлж, дахивар бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх ажлын хүрээнд 13 суманд хоёрдогч түүхий эд хүлээн авах 28 цэг байгуулагдаж, 301,8 тн дахивар хаягдлыг цуглуулан аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг “Эко цэнэ”, “Цэмцгэр” төвүүд болон Улаанбаатар хот руу нийлүүлээд байна. Есөнзүйл, Гучин-Ус, Баян-Өндөр, Уянга, Бүрд, Арвайхээр сумд 2022 онд орон нутгийн хөгжлийн сангийн 69,0 сая төгрөгийн хөрөнгөөр хоёрдогч түүхий эдийг нягтруулах пресслэгч төхөөрөмжийг худалдан авч, аймгийн хэмжээнд 12 сум, 19 пресслэх төхөөрөмжтэй болоод байна.</p> <p>“Арвайхээр тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-аар 2021 оны 10 дугаар сараас эхлэн “Хаягдал хуванцар дахин боловсруулах” үйлдвэр байгуулан үйл ажиллагаа явуулж эхэлсэн. БОАЖГазраас үйлдвэрийг дэмжин байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд нийтийн эзэмшлийн талбайд тарих мод, бутны хамгаалалтын ажилд шаардагдах хоёрдогч түүхий эд боловсруулж хийсэн хашааны шон нийлүүлэх ажилд 18,0 сая төгрөгийн санхүүжилт олгосон.</p> <p>“Азийн хөгжлийн банкны ядуурлыг бууруулах Япон сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй Арвайхээр хотын хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах төслийн хүрээнд Арвайхээр суманд пүү болон хоёрдогч түүхий эд хүлээн авах 5 цэгийг шинээр байгуулж, “Арвайхээр тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-т хүлээлгэн өгсөн.</p>	
9.	2019 оны Дугаар 11/02	Тариф батлах тухай	<p>-Аймгийн хэмжээнд батлагдсан тарифын дагуу орон нутгийн төсөвт хог хаягдлын үйлчилгээний хураамжаас орсон орлогын тодорхой хувийг энгийн хог хаягдлыг булшлах зардал болон хог хаягдлын чиглэлд зарцуулах үйл ажиллагааны зардлыг төсөвт суулгаж, сумдууд төвлөрсөн хогийн цэгийн талбайн хэмжээг багасгах, дарж булшлах ажлыг тогтмол зохион байгуулдаг бөгөөд жилд дундажаар 400-500 сая төгрөгийн хог хаягдлын хураамж сумын төсөвт төвлөрдөг бөгөөд 2022 онд 567,5 сая төгрөгийн хураамж төвлөрч бүх нийтийн их цэвэрлэгээний ажилд 34,9 сая төгрөг зарцуулж, “Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах зорилтот жилийн хүрээнд Есөнзүйл, Гучин-Ус, Баян-Өндөр, Уянга, Бүрд, Арвайхээр сумд 2022 онд орон нутгийн хөгжлийн сангийн 69,0 сая төгрөгийн хөрөнгөөр хоёрдогч түүхий эдийг нягтруулах пресслэгч төхөөрөмжтэй болж, Богд, Баянгол Хархорин сумд орон нутгийн хөгжлийн сангийн 140,9 сая төгрөгийн санхүүжилтээр хог тээврийн автомашин худалдан авч парк шинэчлэл хийсэн байна.</p>	100
10.		Аймгийн зарим	Газар нутгийн байгалийн унаган төрх, хэв шинжийг хадгалах, ховор, ховордсон ургамал, амьтан, усны нөөц, газрын өвөрмөц тогтоц, түүхийн дурсгал бүхий 13	

	2021 оны Дугаар 04/05	газар нутгийг аймгийн тусгай хамгаалалтад авах тухай	сумын нутаг дэвсгэрийг хамарсан 12 газрын 659871.4 гектар талбайг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 04/05, 04/06 дугаар тогтоолоор аймгийн тусгай хамгаалалтад авч, тухайн газарт мөрдөх дэглэмийг баталсан. Тус тогтоолыг Геологи, уул уурхайн кадастрын бүртгэлийн системд бүртгүүлснээр тухайн газарт ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдох боломжгүй болж, байгалийн унаган төрхөөр нь хамгаалах нөхцөл бүрдсэн.	100
11.	2021 оны Дугаар 04/06	Хайрхандулаан сумын зарим газар нутгийг аймгийн тусгай хамгаалалтад авах тухай	Газар нутгийн байгалийн унаган төрх, хэв шинжийг хадгалах зорилгоор Хайрхандулаан сумын Ханхөгшин уул орчмын газрын 27461.7 гектар талбайг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 04/06 дугаар тогтоолоор аймгийн тусгай хамгаалалтад авч, тухайн газарт мөрдөх дэглэмийг баталж уг тогтоолыг Геологи, уул уурхайн кадастрын бүртгэлийн системд бүртгүүлснээр тухайн газарт ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдох боломжгүй болж, байгалийн унаган төрхөөр нь хамгаалах нөхцөл бүрдсэн.	100
12.	2022 оны Дугаар 14/01	Бэлтгэх модны тоо хэмжээг тогтоох тухай	-Ойн тухай хуулийн 17.1.4-д заасны дагуу төрийн захиргааны төв байгууллагын баталсан дээд хязгаарт багтаан тухайн жилд ойгоос бэлтгэх хэрэглээний мод, түлээний хэмжээг сумдаар хуваарилан батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар ой цэвэрлэгээний журмаар мод бэлтгэх ажил нийт 226 га талбайд хийгдэж хэрэглээний мод 6601 шоометр, түлээний мод 16446,7 шоометр, нийт 23048 шоометр мод бэлтгэж ойгоос мод түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлого 161,784,092 мянган төгрөг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Ой цэвэрлэгээгээр мод бэлтгэх ажилд 12 аж ахуйн нэгж, 16 нөхөрлөл оролцсон. Ойгоос мод бэлтгэсэн аж ахуйн нэгж, нөхөрлөлүүд 10 га талбайд ойжуулалт хийж БОХНСАХэмжээний зардлаар 3800 га талбайд ойн хортон хөнөөлт шавжийн устгал тэмцлийн ажил гүйцэтгэлээ.	100
Дундаж үнэлгээ				97.6

